

НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн Баянгол дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2026/017/НА-СТА-ЗГТС

Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2026 он	Санхүүгийн аудит хариуцсан ахлах менежер Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
	Аудитын менежер: С.Гантөгс Утас: 315558 Цахим хаяг: gantugss@audit.gov.mn
	Ахлах Аудитор: Б.Цолмон Утас: 325093 Цахим хаяг: Tsolmonb@audit.gov.mn
	Аудитор: Ж.Мөнхтуяа Утас: 325093 Цахим хаяг: Munkhtuyaja@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
БГД	Баянгол дүүрэг
МУЗГ	Монгол улсын засгийн газар
НТАГ	Нийслэл дэх Төрийн аудитын газар
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТШЗ	Төсвийн шууд захирагч
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХЭДС	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан
ХЭҮЗ	Хөдөлмөр эрхлэлтийн үндэсний зөвлөл



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026.02.25 № 303
танай _____-ны № _____-т

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР
ХАЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ
ГАЗРЫН ДАРГА Б.ГАНЧУЛУУН
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянгол дүүргийн Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн 28.8 сая төгрөгийн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс давсан бөгөөд дангаар буюу нийт дүнгээрээ санхүүгийн тайланд материаллаг нөлөөтэй боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн холбогдох заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Тайлант онд 2,963.5 сая төгрөгийн авлагын үлдэгдэлтэй бөгөөд 629.3 сая төгрөг буюу 21.0 хувь нь хугацаа хэтэрсэн авлага байна. Хугацаа хэтэрсэн зээлийн авлагын 5.42 хувь нь нас барсан иргэдийн, 32.61 хувь нь шүүх ажиллагаанд, 29.49 хувь нь эвлэрлийн хугацаанд, 32.48 нь шүүхийн шийдвэр гүйцэтгэх албанд шилжүүлж авлага барагдуулах арга хэмжээ авч ажилласан байна.

C:\Users\harangua\Desktop\Server\2026\2026\Илтэлийн\2026\02\25\2026.02.25\Дүгнэлт - docx
1426350677

Аудитын гол асуудал

эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр 2025 онд хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйл ажиллагаанд эргэн төлөгдөх нөхцөлтэй 951.0 сая төгрөгийн санхүүгийн дэмжлэгийг 161 иргэнтэй, хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээ, хөдөлмөрт бэлтгэх 74.6 сая төгрөгийн сургалтын зардлыг 14 аж ахуй нэгжтэй гэрээ байгуулан зарцуулсан байна.

Бусад асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь, болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,098,555,770.00	2,963,523,682.63
33	АВЛАГА	3,098,555,770.00	2,963,523,682.63
33300	Татаас, санхүүжилтийн авлага	-	
335	Бусад авлага	32,380,000.00	4,790,000.00
3351	Байгууллагаас авах авлага	27,590,000.00	
3352	Хувь хүмүүсээс авах авлага	4,790,000.00	4,790,000.00
336	Зээлийн авлага	3,066,175,770.00	2,958,733,682.63
3361	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлийн авлага	3,066,175,770.00	2,958,733,682.63
33612	Хувь хүмүүст олгосон зээл	3,066,175,770.00	2,958,733,682.63
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	3,098,555,770.00	2,963,523,682.63
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	1,515,000.00	325,302,606
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	1,515,000.00	325,302,606
413	Өглөг	1,515,000.00	325,302,606
4136	Бусад өглөг	1,515,000.00	325,302,606
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	1,515,000.00	325,302,606
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	3,097,040,770.00	2,638,221,076.63
51	Засгийн газрын хувь оролцоо	3,097,040,770.00	2,638,221,076.63
512	Хуримтлагдсан үр дүн	3,097,040,770.00	2,638,221,076.63
51210	Өмнөх үеийн үр дүн	3,267,022,919.80	3,069,450,770
51220	Тайлант үеийн үр дүн	(169,982,149.80)	(431,229,693.37)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	3,098,555,770.00	2,963,523,682.63

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон /төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	2,139,334,759.00	1,452,963,750.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,139,334,759.00	1,452,963,750.39
120	Нийтлэг татварын бус орлого	2,139,334,759.00	1,452,963,750.39
120004	Төсөвт байгууллагын өөрийн орлого	2,139,173,800.00	1,451,586,000.39
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,003,653,800.00	1,235,978,640.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	135,520,000.00	215,607,360.00

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

120009	Бусад орлого	160,959.00	1,377,750.39
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	2,309,316,908.00	1,884,193,443.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,309,316,908.00	1,884,193,443.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,934,976.88	42,068,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,934,976.88	42,068,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,934,976.88	42,068,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,270,381,931.12	1,842,125,443.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	402,319,262.81	583,202,322.80
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	402,319,262.81	583,202,322.80
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	810,678,572.31	869,400,625.57
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	480,345,601.31	869,400,625.57
213304	Хөрөнгийн	330,332,971.00	
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	136,060,959.00	86,305,110.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	136,060,959.00	86,305,110.39
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	921,323,137.00	303,217,385.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	921,323,137.00	303,217,385.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(169,982,149.00)	(431,229,693.37)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	164,300,220.05	(431,229,693.37)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	2,470,047,730.80	1,452,963,750.39
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	2,470,047,730.80	1,452,963,750.39
120	Нийтлэг татварын бус орлого	2,470,047,730.80	1,452,963,750.39
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	2,469,506,771.80	1,451,586,000.39
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,003,653,800.00	1,235,978,640.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	135,520,000.00	215,607,360.00

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ САНГИЙН 2025 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

1200043	Урьд оны үлдэгдэлээс санхүүжих	330,332,971.80	
120009	Бусад орлого	540,959.00	1,377,750.39
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	-	
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	3,416,906,908.00	2,511,405,837.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,416,906,908.00	2,511,405,837.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	38,934,976.88	42,068,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	38,934,976.88	42,068,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	38,934,976.88	42,068,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,377,971,931.12	2,469,337,837.76
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,509,909,262.81	1,210,414,716.80
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,509,909,262.81	1,210,414,716.80
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	480,345,601.31	869,400,625.57
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	480,345,601.31	869,400,625.57
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	466,393,930.00	86,305,110.39
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	466,393,930.00	86,305,110.39
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	921,323,137.00	303,217,385.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	921,323,137.00	303,217,385.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	(946,859,177.20)	(1,058,442,087.37)
14	Бусад эх үүсвэр	946,859,178.00	1,058,442,087.37
145004	Дотоод эх үүсвэрээс олгосон зээлээс эргэж төлөгдөх	946,859,178.00	1,058,442,087.37
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	946,859,178.00	1,058,442,087.37
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)		
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	946,859,178.00	1,058,442,087.37
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,097,040,770.00	3,097,040,770.00
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,097,040,770.00	3,097,040,770.00
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	0.00
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	3,097,040,770.00	3,097,040,770.00
D01	2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	3,097,040,770.00	3,097,040,770.00
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-27,590,000.00	-27,590,000.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	3,069,450,770	3,069,450,770
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	0.00
D08	Тайлант үеийн үр дүн	-431,229,693.37	-431,229,693.37
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,638,221,076.63	2,638,221,076.63

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон.

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,944,578,640.00	1,252,482,716.80	692,095,923.20	64.4
УРСГАЛ ЗАРДАЛ	1,944,578,640.00	1,252,482,716.80	692,095,923.20	64.4
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	60,370,000.00	42,068,000.00	18,302,000.00	66.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	60,370,000.00	42,068,000.00	18,302,000.00	66.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	60,370,000.00	42,068,000.00	18,302,000.00	66.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,884,208,640.00	1,210,414,716.80	673,793,923.20	64.2
Бусад урсгал шилжүүлэг	1,884,208,640.00	1,210,414,716.80	673,793,923.20	64.2
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,884,208,640.00	1,210,414,716.80	673,793,923.20	64.2
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,944,578,640.00	1,252,482,716.80	692,095,923.20	64.4
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,944,578,640.00	1,252,482,716.80	692,095,923.20	64.4
ЗГ-н тусгай сангаас санхүүжих	1,944,578,640.00	1,252,482,716.80	692,095,923.20	

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 28,820.0 мянган төгрөгийн зөрчил¹ илэрснээс, 28,820.0 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 3 зөвлөмж хүргүүллээ.

Нийт илрүүлсэн 28,820.0 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр тул “Хязгаарлалттай” дүгнэлт өглөө.

5.2 Зөвлөмж

1. Нийт зардлын данстай холбоотой асуудал

Илрүүлэлт-1: Өмнөх онд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон 17,800.0 мянган төгрөгийн санхүүгийн дэмжлэгийн төлөлт дутуу хугацаа хэтэрсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*”, Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн гэрээ 2 дугаар зүйлийн 2.10-т “*Энэхүү гэрээг дүгнэж арга хэмжээнд заасан шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг хангасан эсэхэд хяналт тавина.*”, 2.11-т “*Санхүүгийн дэмжлэгийн явцын хяналт, гүйцэтгэлийн хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлнэ*” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон санхүүгийн дэмжлэгийг гэрээнд заасан хуваарийн дагуу төлүүлэх.

Илрүүлэлт-2: Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан болон ажлын байр дэмжих хөтөлбөрүүдээс тайлант онд иргэдэд олгосон санхүүгийн дэмжлэгээс 11,020.0 мянган төгрөг гэрээний хавсралт хуваарийн дагуу төлөгдөөгүй байгаа нь авлага нэмэгдэх үр дагаварт хүргэсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т “*батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих*”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “*дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах*”, Эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэгийн гэрээ 2 дугаар зүйлийн 2.10-т “*Энэхүү гэрээг дүгнэж арга хэмжээнд заасан шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг хангасан эсэхэд хяналт тавина.*”, 2.11-т “*Санхүүгийн дэмжлэгийн явцын хяналт, гүйцэтгэлийн хяналтыг зохих журмын дагуу хэрэгжүүлнэ.*”, 4 дүгээр зүйлийн 4.3-д “*Б тал гэрээний дагуу олгосон санхүүгийн дэмжлэгийг зориулалтын бусаар зарцуулсан, бусдад дамжуулсан, ашиглуулсан, хуурамч баримт бичиг бүрдүүлсэн, үйлдсэн нь тогтоогдсон тохиолдолд А талд учруулсан хохирол (шүүхийн зардал Үндэсний аудитын байгууллагын акт, улсын байцаагчийн албан шаардлага, актаар тогтоогдсоныг)-ыг бүрэн хариуцна.*” гэж заасантай тус тус нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Өгсөн зөвлөмж: Санхүүгийн дэмжлэгийн гэрээний хавсралт хуваарийн дагуу зээлийг хугацаанд нь эргэн төлүүлэх, хяналтыг сайжруулах, авлагыг нэмэгдүүлэхгүй байхад анхаарах, зөрчлийг давтан гаргахгүй ажиллах.

Илрүүлэлт-3: Нас барсан иргэдийн авлагад эрсдлийн сан үүсгэх талаар холбогдох журам байхгүй, НБББББ-т тусгаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-т *"батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих"* гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байдал" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох дээд шатны байгууллагад санал хүргүүлж шийдвэрлүүлэх

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Өмнөх онд эргэн төлөгдөх нөхцөлтэй олгосон санхүүгийн дэмжлэгийн төлөлт дутуу байна.	1	17,800.0					1	17,800.0				
Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, ахмад настан болон ажлын байр дэмжих хөтөлбөрүүдээс тайлант онд иргэдэд олгосон санхүүгийн дэмжлэггэрээний хавсралт хуваарийн дагуу төлөгдөөгүй	1	11,020.0					1	11,020.0				
Нас барсан иргэдийн авлагад эсрдлийн сан үүсгэх талаар холбогдох журам байхгүй, НБББББ-т тусгаагүй байна.	1						1					
Дүн	3	28,820.0					3	28,820.0				